

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.11.22

Байгууллагын гүйцэтгэсэн ажлын мэдээг долоо хоног бүр БОАЖЯам болон ЗДТГ руу цахимаар хүргүүлэн ажиллав.

5 иргэн, 4 ААНэгж байгууллагын төслийн баримт бичигт БОНБЕҮнэлгээний дүгнэлт, 5 иргэн, ААНэгжүүдэд ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Өлгий сумын 4 , 5 , 11 дүгээр багуудын иргэдэд зориулсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэн таны оролцоо чухал ” сэдэвт сургалт, уулзалтад БОАЖГазрын холбогдох албан хаагчид оролцож орчны бохирдол хог хаягдлын талаар сургалт явуулж, угаарын хийн тухай брошур тарааж ажиллав.



Баруун бүсийн БОАЖГазрын мэргэжилтнүүдийг чадавхжуулах "Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил" сэдэвт уулзалт, сургалт , спортын арга хэмжээ Ховд аймагт зохион байгуулагдаж холбогдох албан хаагчид оролцов.



"ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО" ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ холбогдох албан хаагчид оролцов.



Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын нарийн гүүрийн дэргэд аймгийн байгаль хамгаалах сангийн 12 сая төгрөгийн санхүүжилтээр баригдсан отоглох, хоноглох цэгийг аймгийн Засаг даргаар байгуулсан ажлын хэсэг хүлээж авах ажлыг зохион байгууллаа.



“Эрсдэл ба стандарт” сэдэвт гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний форумыг Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс хамтран зохион байгуулсан форумд байгууллагын холбогдох албан хаагчид оролцлоо..



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

“Ник петровис” ХХК-ийн Баян -Өлгий аймаг дахь салбарын газрын тоосны бүтээгдэхүүний агуулах болон Өлгий сумын төвд байрлалтай 2,3,4,5,6,7,8-р шатахуун түгээх станцуудын үйл ажиллагаанд 01.1.4 кодтой хяналтын хуудсаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж эрсдэлийг үнэлж ажилласан ба шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй холбогдуулан “Ник Петровис” ХХК-д зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж 500 нэгж буюу 500,000 төгрөгийн шийтгэл ногдуулж, зөрчлийг бүрэн арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны хугацаат даалгавар өгч ажиллав. “Азат” ХХК-ийн мал төхөөрөх үйлдвэр, газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхэлж буй “Тэс петоролиум” ХХК, “Шунхлай” ХХК-ийн Баян – Өлгий аймаг дахь салбаруудын газрын тоосны бүтээгдэхүүний агуулгахын үйл ажиллагаанд 01.1.4 кодтой хяналтын хуудсаар тус тус гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, эрсдэлийг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР:

Монголын аялал жуулчлалын салбарын нэгдсэн цугларалт, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ, борлуулалт, танилцуулгыг олон нийтэд хүргэх “ITM-Монголиа”-2023 үзэсгэлэн энэ сарын 27-ноос 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, тус үзэсгэлэнд Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын "Grand Altai travel LLC", "Discover kazakh nomads LLC", "Altai trekking", "Altai lodje", "Bear valley", "Eagle hunter tourist camp", "Lena tour agency" "Cayan" алтайн барагшун, "Асыл мура" "Ашық аспан" компаниуд оролцов.

Энэ удаагийн үзэсгэлэнг дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагатай уялдуулж “Ногоон хөрөнгө оруулалт-Бидний ирээдүй” уриан дор зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, шинэ үеийн хөгжлийн бодлогыг сурталчлан таниулах хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн байна.



БОАЖЯамны АЖБЗГазраас зохион байгуулсан Аялал жуулчлалын "GO TO MONGOLIA" үндэсний чуулганд Баян-Өлгий аймгийг төлөөлөн оролцож, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал ба цаашид хийх бодлогыг хэлэлцүүлэв.



ОЙН ТАЛААР:

Аймгийн хэмжээнд намрын мод тарилтаар нийт 18826 ширхэг 10 төрлийн мод, бут сөөг таригдаж, 136 аж ахуй нэгж, байгууллага, 4469 иргэн хамрагдав.

АМЬТНЫ ТАЛААР:

Амьтны тухай хууль, тогтоомж, нөөцийн ашиглалт, хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан хэлэлцүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх цахим уулзалтад оролцов.

УСНЫ ТАЛААР:

Мал зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэн газрын доройтлыг бууруулах зорилгоор Баян – Өлгий аймгийн Бугат, Алтай сумын чухал ач холбогдолтой 2 булаг шандны эхийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн санхүүжилтээр тус бүр 3 сая төгрөгийн өртөгтэй хашиж хамгаалах ажлыг Кенже – Дара ХХК гүйцэтгэж орон нутагт хүлээлгэж өгөв.





ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР:

Буянт сумын төвд байгалийн нөөц ашигласны төлбөрийн 6,550,000 төгрөгийн санхүүжилтээр сумын нийтийн нүхэн жорлонг буулгаж шинээр стандартын шаардлага хангасан эко жорлон болон ангилан ялгах хогийн сав байршуулав.



Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/735 дугаар захирамжаар “Цэвэр цэмцгэр – Өлгий” уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг Өлгий хот дотор 11 сарын 21 өдөр зохион байгуулж 120 гаруй ААНэгж , байгууллага иргэд оролцож орчин тойрныхоо хог хаягдлыг бүрэн цэвэрлэв.



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР